

**Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар**



ХЭА-2018-02-ГА

**“АРХИГҮЙ ХЭНТИЙЧҮҮД” ХӨТӨЛБӨРИЙН 2014-2016
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА –ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**



**“Архигүй Хэнтийчүүд”
хөтөлбөрийн үр дүнг тооцож
дүгнээгүй болжээ.**

Өндөрхаан хот

2018 он

АГУУЛГА		
Тайлан бэлтгэсэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Аудитын менежер: Д.Оюунтуяа Ахлах аудитор: Д.Эрдэнэбилэг Аудитор: Ц.Нарангэрэл 2018 оны 09 дүгээр сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 70562112 факсаар харилцана уу. Хаяг: Хэнтий аймаг Хэрлэн сум АЗДТГ-ын байр. 320 тоот өрөө	Агуулга	
	Товчилсон үгийн тайлбар	
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	
	Ерөнхий мэдээлэл	
	Бүлэг 1: Аймгийн хэмжээнд хөтөлбөрийг боловсруулж батлуулсан бол сумдад дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажил хангалтгүй хийгджээ. - Сумдад дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажил хангалтгүй хийгдсэн байна. - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг боловсруулах сумдын тоо жил өнгөрөх тутам буурсан байна. - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг үндсэндээ аймаг, сумын ОНХС-аас санхүүжүүлсэн байна.	
	Бүлэг 2: “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажлууд зохион байгуулсан байна. “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, эрүүл мэндийн төвүүд хамтран ажилласан байна. - Хөтөлбөрт хамрагдсан иргэдийг ажлын байраар хангах, мэргэжил олгох, өөрийн орлоготой болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. - Цэнхэрмандал, Баян-Адарга сумдаас бусад сум, тосгон хөтөлбөр хэрэгжүүлсэн тайлангаа ирүүлэх талаар хангалтгүй ажиллажээ. Бүлэг 3: Ихэнх сум, тосгонд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдээгүй, хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна. - Нийт сум, тосгодод хэрэгжсэн “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийгдээгүй байна. - Дийлэнх сум, тосгон хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна. - Хөтөлбөрийн талаархи мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.	
	Аудитын дүгнэлт	
	Аудитын зөвлөмж	
	Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн санал	
	Аудитын тайлангийн баталгаажуулалт	
	Аудитаар илэрсэн зөрчил ба акт, албан шаардлагын жагсаалт.	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТББ	Төрийн бус байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБУ	Хэрлэнбаян-Улаан
ГХУСС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын нэр: “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаа

Аудитын код: ХЭА-2018-02-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 сарын 05 өдрийн А/05 тушаалыг үндэслэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гарган аудитын дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг боловсруулж батлуулсан эсэх,
- Хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх санхүүжилтийг бүрэн олгож, хөтөлбөрийг хэрэгжүүлж чадсан эсэх,
- “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдэж, үр дүнг тооцсон эсэх,

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймаг болон сумын Засаг даргын Тамгын газар, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон төрийн болон ТББ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, үйл ажиллагааны тайлан, судалгаа, бүртгэл тайлагнал, статистик мэдээ, дүн шинжилгээний бусад материалыг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд стандарт, журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийн, лавлагаа, тодруулга аван, судалгаа, тайлан зэрэг баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж ажиллалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитыг гүйцэтгэхэд аудитын удирдамж АДБОУС 3000, 3100 болон төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”,
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал “ОНХС-ийн заавар”,
- Аймгийн ИТХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөр,
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд,

Ерөнхий мэдээлэл

Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг баталж, аймгийн Засаг даргын 2013 оны А/63 дугаар захирамжаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулжээ.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг 2013-2016 оны хооронд хэрэгжүүлснээр архидан согтуурснаас үүдэн гарч буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, ард иргэдийн амгалан тайван байдлыг хангах, архины хамааралтай иргэдийн эрүүл мэнд, нийгэмд үүсч буй сөрөг үр дагавруудыг арилгах үүднээс төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагууд, иргэдийн идэвх санаачлага, оролцоог нэмэгдүүлэн, тэдгээрийн хамтын уялдаа холбоог бий болгоход чиглэгджээ.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг аймгийн хэмжээний 22 сум, тосгоноос Гурванбаян тосгон хэрэгжүүлээгүй бол 12 сум, тосгоны Засаг даргын Тамгын газар буюу нийт сумдын 54,5% нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан баталжээ.

Хэнтий аймгийн хэмжээнд 2014-2016 онуудад аймаг, сумын ОНХС-аас 585,6 сая төгрөгийг “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг санхүүжүүлэхээр баталсан ба бусад эх үүсвэрээс хөрөнгө нэмж батлаагүй байна.

Жилийн эцсийн гүйцэтгэлээр аймаг, сумын ОНХС-аас 504,1 сая төгрөг, хандиваар 28,2 сая төгрөг, архины хамааралтай иргэдийн эмчилгээний зардлын өөрөө хариуцан гаргасан 71,6 сая нийтдээ 603,9 сая төгрөгийг архинаас хамааралтай иргэдийн эмчилгээний төлбөр, сургалт, томилолтын зардал, тээвэр шатахуун, жолоочийн хөлс, хоол, уралдаан тэмцээн, бэлэг дурсгал болон бусад зардлуудад зарцуулсан байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 1262 иргэн архины хамааралтай гэсэн судалгаа гарснаас 903 иргэнийг хөтөлбөрт хамруулж 443 иргэн архины хамаарлаасаа гарсан бол, 263 иргэн давтан хэрэглэсэн, 80 иргэн архины хамаарлаасаа салж чадаагүй байна.

Хөтөлбөрийн хүрээнд 14 ТББ-тай хамтран ажилласны зэрэгцээ 12 сумын эрүүл мэндийн төвүүд архинаас гаргах эмчилгээнд иргэдийг хамруулжээ.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрт хамрагдан архины хамаарлаасаа салсан иргэдийг ажлын байртай болгох, мэргэжил эзэмшүүлэх, амьдралд нь дэм болох үүднээс 164 иргэнд 278,9 сая төгрөгийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгож, 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгүүлжээ.

Мөн 107 иргэнийг сургалтанд хамруулж, 194 иргэнийг түр болон байнгын ажлын байраар хангах ажлыг зохион байгуулжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг 14 сум, тосгон эцэслэн дүгнэж сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

•АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛСАН БОЛ СУМДАД ДЭД ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ ХИЙГДЖЭЭ.

А.1. Сумдад дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажил хангалтгүй хийгджээ.

Хэнтий аймгийн хэмжээнд 2013-2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газар боловсруулан Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23 тоот тогтоолоор “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг баталсан байна.

Улмаар аймгийн Засаг даргын 2013 оны А/63 дугаар захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан 19 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Гурванбаян тосгонд тус хөтөлбөр хэрэгжээгүй, үлдсэн сум, тосгонд хэрэгжсэнээс 12 сум, тосгоны Засаг даргын Тамгын газар дэд хөтөлбөрийг боловсруулж сумын ИТХ болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан бол 9 сум, тосгонд дэд хөтөлбөргүйгээр хэрэгжүүлсэн байна.

Батноров, Батширээт, Хэрлэн, Баян-Овоо, Галшар, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сумд Бэрх, ХБУлаан тосгон дэд хөтөлбөр боловсруулж батлуулаагүй байна.

Мөн “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хүрээнд 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 11 сумдын Засаг даргын Тамгын газар боловсруулсан бол 10 сум, тосгоны Засаг даргын Тамгын газарт хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах¹ ажил хийгдээгүй байна.

Хэрлэн, Батширээт, Баянмөнх, Галшар, Дархан, Цэнхэрмандал, Бор-Өндөр сумдын ЗДТГ, ХБУлаан, Өлзийт, Бэрх тосгоны Захирагчийн ажлын алба төлөвлөгөө боловсруулаагүй.



¹ 3.5.8-ын 1 “Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, ...”

A.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг боловсруулах сумдын тоо жил өнгөрөх тутам буурсан байна.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй, тодорхой болгох үүднээс жилийн төлөвлөгөө гаргаж ажиллахаар хөтөлбөрт тусгагдсанаас 6 сумын засаг даргын Тамгын газар жил бүрийн төлөвлөгөөг бүрэн боловсруулж, 14 сум, 2 тосгоны Засаг даргын Тамгын газарт жил бүрийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажил дутуу хийгджээ.

Баянхутаг, Биндэр, Дадал, Норовлин, Өмнөдэлгэр, Баян-Адрага сумдын Засаг даргын Тамгын газар 2014-2016 онуудад жилийн төлөвлөгөөг тухай бүр боловсруулан батлуулж ажилласан байна.

Харин тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн хэмжээний нэгтгэсэн төлөвлөгөөг аймгийн ЗДТГ, сумын жилийн ажлын төлөвлөгөөг Хэрлэн, Баянмөнх, Галшар, Бор-Өндөр сумд, ХБУлаан тосгоны Захирагчийн ажлын алба боловсруулан гаргаагүй байна.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг төлөвлөхдөө 2014 онд 21 сум, 2015 онд 20 сум, 2016 онд 18 сумын Засаг даргын Тамгын газар, Тосгоны Захирагчийн ажлын алба боловсруулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд иргэдээс санал авч батлуулжээ.

Харин Баянхутаг сум 2015 онд, Батширээт, Галшар, Баянмөнх сумдын Засаг даргын Тамгын газар 2016 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөнд иргэдээс санал, хүсэлт авсан талаар баримт материал аудитад хамрагдсангүй.

A.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын дийлэнхийг сумын ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

Хэнтий аймагт хэрэгжүүлсэн "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрт 2014-2016 онуудад нийтдээ 585.6 сая төгрөгийг аймаг, сумын ОНХС-аас зарцуулахаар батлагдсан байна.

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зардлыг жил бүрийн төсөвт ОНХС-аас зарцуулахаар баталж, санхүүжүүлж байсан ба хандив, тусламж болон архины хамааралтай иргэдийн өөрсдийнх нь гаргасан зардлыг төлөвлөгөөнд тусгаж батлаагүй байна.


Иймээс тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлыг тооцож төлөвлөгөөгүй гэж үзлээ.

Аудит хийгдэж буй 2014-2016 онуудад тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд 9 сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллага 28.2 сая төгрөгийн хандив, дэмжлэгийг үзүүлсэн байна.

Мөн "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хүрээнд 2014-2016 онуудад архины хамаарлаас гаргах эмчилгээнд хамрагдсан 11 сумын 167 иргэн эмчилгээний зардлын тал хувийг хариуцан гаргасан нь 71.6 сая төгрөг болжээ.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2014-2016 онуудад аймаг, сумын ОНХС-аас 585.6 сая төгрөгийн төсвийг баталж, 504.1 сая төгрөгийг тус хөтөлбөрийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлснээс Бор-Өндөр, Цэнхэрмандал, Батноров зэрэг сумдын Засаг даргын Тамгын газар, Бэрх, ХБУлаан тосгоны Захирагчийн ажлын алба нь хөтөлбөрт зориулсан санхүүжилтийг бүрэн зарцуулсан бол бусад сумд 81.5 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Мөн “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 12,6 сая төгрөгийг тус тус дэмжлэг болгон Бэрх тосгон, Хэрлэн, Бор-Өндөр, Баянмөнх сумдын Засаг даргын Тамгын газарт “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан олгосон байна.



Аудитад хамрагдсан 2014-2016 онуудад аймгийн хэмжээнд “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрт 3 төрлийн эх үүсвэрээс нийтдээ 603,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

•“АРХИГҮЙ ХЭНТИЙЧҮҮД” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ТОДОРХОЙ АЖЛУУД ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.1. “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, Эрүүл мэндийн төвүүд хамтран ажилласан байна.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд архинд донтсон, архины хамааралтай иргэдийн судалгааг сумдаас авч нэгтгэхэд нийтдээ 1262 иргэн архины хамааралтай гэсэн дүн мэдээтэй байна.

Архины хамааралтай иргэдийг архинаас гаргах зорилгоор 21 сумын Засаг даргын Тамгын газар нь “Монгол Ви И Ти Нет” ТББ, “Өөрийгөө өөрчлөн-өөдрөг амьдарья” ТББ, “Монгол Манукол академи”, “Хелл интернэшнл” ТББ, “Монгол өрх сэтгэлзүйн хүрээлэн”, “Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг”, “Инээмсэглэж буй гэр бүл” ТББ, “Сэтгэлийн хөгжил”, “Эр зориг эрүүл амьдрал” ТББ, “Монголын эрүүл идэвхитэй амьдралын клуб”, “Гоё амьдрал” ТББ, Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ, “Мандах наран” ТББ, “Жинхэнэ эр хүн” ТББ, “Төгс төлөвшил” ТББ-тай хамтран ажиллаж архинаас гаргах эмчилгээ болон архины хамааралтай иргэдэд сургалт хийх, ажлын байртай болгох ажлуудыг зохион байгуулжээ.

Дээрхи төрийн бус байгууллагуудаас Хэнтий аймгийн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулдаг “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ нь иргэдийг архины хамаарлаас гаргах, тэднийг ажлын байраар хангах талаар тогтвортой үйл ажиллагаа явуулж өнгөрсөн хугацаанд Дадал, Биндэр, Бор-Өндөр, Галшар, Норовлин, Батноров, Баян-Овоо, Баянхутаг, Хэрлэн, Дэлгэрхаан сумд, Тахилгат, Өлзийт тосгоны иргэдэд архины эсрэг сургалтыг зохион байгуулсан, архинд донтсон 87 иргэнийг архины эмчилгээнд хамруулснаас 42 иргэн архинаас гаргасан байна.

Тэдгээр архины хамаарлаасаа салсан хүмүүсээс 6 хүнийг байнгын ажлын байртай, 8 хүнийг орон гэртэй болгох ажлыг тус төрийн бус байгууллага зохион байгуулж үр дүнд хүрсэн байна.

Хэрлэн сумын Б.Итгэлсүрэн, Б.Эрдэнэбат, Б.Ариунбаатар, Ц.Бат-Эрдэнэ, С.Энх-Од, Д.Ганхуяг нарыг ажлын байртай, Б.Итгэлсүрэн, С.Энх-Од, Ш.Хүрэлбаатар, Л.Ганбаатар, Ганбат, Х.Эрдэнэсүрэн, Б.Батсүх, Ц.Намхай нарыг гэртэй болгожээ.

Улмаар архины хамааралтай хүмүүст сургалт явуулах “Амьдралын аваргууд” 80 м2 талбайтай сургалтын төвийг өөрсдийн хүчээр барьж байгаа ба үүнд аймгийн Засаг даргаас 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Мөн архины хамааралтай иргэдийг эмчлэж эрүүлжүүлэх үүднээс 12 сумын Засаг даргын Тамгын газар, сумын Эрүүл мэндийн төвтэйгээ хамтран ажиллах гэрээ байгуулан хөтөлбөрт хамрагдсан иргэдийг хэвтүүлэн эмчилсэн байна.

Харин үлдсэн сум Эрүүл мэндийн төвтэйгээ иргэдийг архинаас гаргах эмчилгээнд хамруулах талаар хамтран ажилласан эсэх нь тодорхойгүй байна.

Хэнтий аймгийн хэмжээнд гаргасан судалгаагаар 1262 хүн архинаас хамааралтай байгаагаас “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрт 903 иргэн буюу 71.6%-ийг архины хамаарлаас гаргах эмчилгээ болон сургалтанд хамруулсан байна.

Б.2. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийг ажлын байраар хангах, мэргэжил олгох, өөрийн орлоготой болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 2014-2016 онуудад хооронд 379.2 сая төгрөгийг архины хамааралтай иргэнийг архины хамаарлаас гаргах сургалт, эмчилгээнд, 51.5 сая төгрөгийг архины эсрэг сургалт, сурталчилгааг хэвлэл мэдээлэл, уралдаан тэмцээн болон баримтат кинонд, 3.8 сая төгрөгийг баярын арга хэмжээ, бэлэг дурсгалд, 69.6 сая төгрөгийг шатахуун, ажлын хөлс, томилолт, буудлын зардал, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан тэмцээнд оролцогчдын хувцасны болон тайзны материал, бусад зүйлд тус тус зарцуулсан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд 2015 оны эхний хагас жилийн тайлангаар архины хамааралтай 320 иргэнийг хөтөлбөрт хамруулахаар төлөвлөснөөс 73.7 хувь буюу 236 иргэн хөтөлбөрт хамрагдан архины хамаарлаас гаргасан дүн мэдээ байгаагаас Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар 15 иргэнийг архинаас бүрэн гаргасан тухай “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн биелэлтийг тайлагнасан тайландаа мэдээлсэн бол бусад сумд энэ талаар тодорхой тайлагнаагүй байна.


Харин 2015 оны жилийн эцсийн байдлаар 443 иргэн архины асуудлаа бүрэн шийдсэн, 263 иргэн хэд хэдэн удаа давтан уусан бол 80 иргэн эмчилгээнд хамрагдсан ч гэсэн архины хамаарлаасаа салж чадаагүй гэсэн дүн гарсан байна.

2015 оны байдлаар архины хамааралтай 793 иргэн архины хамаарлаас гаргах эмчилгээнд хамрагдсанаас 10.2% буюу 80 иргэн архины хамаарлаасаа салж чадаагүй байна.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрт хамрагдан архины хамаарлаасаа салсан иргэдийг дэмжиж ажлын байраар хангах, тэднийг ажилтай орлоготой болгох үүднээс 164 иргэнд 15.2 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 254.1 сая төгрөгийн зээл, 9.6 сая төгрөгийн гэр олгож, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс 105.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгүүлжээ.

Мөн 107 иргэнийг мэргэжил олгох сургалтанд, 194 иргэнийг түр болон байнгын ажлын байраар хангах ажлыг 14 сум зохион байгуулсан талаар мэдээлсэн байна.

Архины хамаарлаас гарсан иргэдэд үзүүлсэн тусламж



Бор-Өндөр, Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар, Өлзийт, ХБУлаан тосгоны Захирагчийн ажлын алба 2014-2016 онуудад, Галшар сумын ЗДТГ 2015 онд архины хамаарлаас гарсан иргэдийг ажлын байраар хангах талаар хийгдсэн ажлын мэдээлэл тодорхойгүй байна.

Б.3. Цэнхэрмандал, Баян-Адарга сумдаас бусад сум, тосгон хөтөлбөр хэрэгжүүлсэн тайлангаа ирүүлэх талаар хангалтгүй ажиллажээ.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгээгүй тул орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгө байхгүй байна.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг сум, тосгон бүр жилд 2 удаа аймгийн комисст ирүүлэхээр хөтөлбөрт тусгасны дагуу аудитад хамрагдсан 2014-2016 онуудад Цэнхэрмандал, Баян-Адрага сумдын Засаг даргын Тамгын газар 6-9 удаа, Батширээт, Баянхутаг, Галшар, Норовлин, Баян-Овоо сумдын ЗДТГ, Бэрх тосгоны Захирагчийн ажлын алба 4-5 удаа, бусад сумдын ЗДТГ 1-3 удаа тайлан ирүүлж, 3 сум, тосгоны ЗДТГ болон Захирагчийн ажлын алба нэг ч удаа тайлан ирүүлээгүй байна.

Жаргалтхаан сумын ЗДТГ, Өлзийт, ХБУлаан тосгоны Захирагчийн ажлын алба 2014-2016 онуудад хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар тайланг ирүүлээгүй байна.

**ГУРАВДУГААР
БҮЛЭГ**

**•ДИЙЛЭНХ СУМ, ТОСГОНД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙГЭЭГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЖ
ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.**

В.1. Нийт сум, тосгодод хэрэгжсэн "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийгээгүй байна.

2013 онд Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Хууль зүйн яамнаас Хэнтий аймагт хийсэн шалгалтаар "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөр боловсруулан

хэрэгжүүлж, архины хамааралтай иргэдийг эрүүлжүүлэх, ажлын байраар хангах, мэргэжилтэй болгох зэргээр тодорхой үр дүнтэй ажилласныг үнэлэн Хэнтий аймгийн ГХУС салбар зөвлөлийн үйл ажиллагаанд мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна.

Харин Хэнтий аймгийн орон нутгийн захиргааны байгууллага, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгээс хөтөлбөр хэрэгжиж байгаа 21 сум, тосгонд “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн жилийн төлөвлөгөө, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт огт хийгдээгүй² байна.

Мөн хөтөлбөрт тусгагдсаны дагуу сумдын ИТХ, Засаг дарга 2014-2016 онуудад хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж үр дүнг тооцоогүй байна.

В.2. Дийлэнх сум, тосгон хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөр нь нийгэмд үзүүлэх нөлөөлөл, ач холбогдох ихтэй арга хэмжээ боловч хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүй, үр өгөөжийг тооцоогүй нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг хангалтгүй ажилласан гэж үзэж байна.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хэрэгжилтийг Батширээт, Баян-Овоо, Баянхутаг, Дадал сумдын ЗДТГ жилийн эцэст дүгнэсэн бол бусад 17 сум, тосгон хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тухайн сумын ЗДТГ тооцоогүй байна.

Хэрлэн, Батноров, Баянмөнх, Биндэр, Галшар, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Бор-Өндөр, Баян-Адрага сумдын ЗДТГ, ХБУлаан, Өлзийт, Бэрх тосгоны Захирагчийн ажлын алба зэрэг 17 сум, тосгон хөтөлбөрийн үр дүнг дүгнээгүй.

Мөн Батширээт, Баянмөнх, Баян-Овоо, Баянхутаг, Жаргалтхаан, Бор-Өндөр сумдын ЗДТГ, Бэрх тосгоны Захирагчийн ажлын алба жилийн эцэст Засаг дарга, Захирагчийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын ИТХ болон багийн Иргэдийн нийтийн хуралд тайлагнахдаа “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн үр дүнг хамтад нь хэлэлцүүлсэн байна.

Хэрлэн, Дэлгэрхаан, Батноров, Биндэр, Галшар, Дадал, Дархан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Баян-Адрага сумдын ЗДТГ, ХБУлаан, Өлзийт тосгоны Захирагчийн ажлын алба зэрэг 14 сум, тосгон “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сумын ИТХурлаар хэлэлцүүлээгүй байна.

В.3. Хөтөлбөрийн талаархи мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.

“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн талаар иргэдэд таниулах, хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох ажлын хүрээнд Хэнтий аймгийн “Өндөрхаан”, “Хэнтий” телевиз, “Хэнтий мэдээ”, “22 Ньюс” сонины газартай хамтран ажиллах гэрээ байгуулан “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хүрээнд олон нийтийг хамарсан “Дэвжээ” тэмцээн зохион байгуулж, мэдээ, мэдээлэл, сурвалжлага, шторк, рекламьг үзэгч олон нийтэд хүргэж ажиллажээ

² 4.1.2 “Сумдад хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлыг Засаг даргын томилсон ажлын хэсэг хариуцна.

4.1.3 Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ”

Мөн хөтөлбөрт хамрагдаж архины хамааралгүй болсон иргэдийн тухай "Амьдрал чамайг мартаагүй", "Өөдрөг амьдралд тэмүүлсэн он жилүүд" баримтат кино хийж, "Архигүй Хан Хэнтий" дууны клип гаргаж үзэгчдэд хүргэсэн байна.



Хэрлэнбаян-Улаан тосгонд "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн хүрээнд иргэд рүү чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулагдсан ажлын тайлан байхгүй байна.

"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийн 2015 оны хэрэгжилтийн дүнгээр тус хөтөлбөрт хамрагдсан 793 иргэнээс 443 иргэн буюу 55.8 хувь нь архины асуудлаа бүрэн шийдсэн мэдээ байгаа боловч хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнээгүй, түүнд хяналт шалгалт хийгдээгүйгээс хөтөлбөрийн эцсийн үр дүн гэж үзэх боломжгүй байна.



"Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үр дүнгийн талаар 2015 онд гаргасан судалгаагаар дүгнэхэд тус хөтөлбөрт хамрагдсан 793 иргэнээс 263 иргэн буюу 33.1 хувь нь архи хэд хэдэн удаа уусан, 80 хүн буюу 10 хувь нь архины хамааралтай хэвээрээ байна.

Харин 2014, 2016 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэсэн талаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн ажлын хэсэг болон сумдын Засаг даргын Тамгын газраас аудитын хугацаанд материал ирүүлээгүй тул тухайн онуудад хөтөлбөрийн үр дүнг тооцсон гэж үзэх үндэслэлгүй байна.

Харин "Архигүй Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, зарцуулсан зардлын гүйцэтгэлийн талаар иргэдэд мэдээлэл тогтмол хийж байжээ.

ОНХСангаас “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан 485.7 сая төгрөгийн зарцуулалтыг жил бүр сум, багийн ИНХ-аар иргэдэд танилцуулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлах талаар сумд хангалтгүй ажилласан байна.
2. Тус хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн дийлэнхийг аймаг, сумын ОНХС-аас зарцуулсан байна.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тогтмол тооцож тайлагнадаггүй, хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдээгүй байна.
4. Аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын комисс нь сумдад хэрэгжсэн хөтөлбөрийн тайланг авч аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-д танилцуулах ажил хийгдээгүй байна.
5. “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хүрсэн үр дүнг тооцох аймгийн ажлын хэсэг хангалтгүй ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар танаа

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайланг сум бүрээс авч нэгтгэх, цаашид хэрэгжилтийг сайжруулах үүднээс жил бүрийн зорилтыг тодотгон гаргаж байх,
- Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг жил бүр тооцож тайлагнадаг, хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьж ажилладаг байх,

Аудитын тайланд дурьдсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хийгдсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг 2019 оны 12 сарын 15-ны дотор гаргаж ирүүлнэ үү.

2018 оны 09 дугаар сарын 26

**Холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн
албан тоот**

Тайлбар

 ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12 E-mail: khentii@audit.gov.mn 2018.10.12 № 104 танай -ы № -т ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБААТАР ТАНАА Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлж байна. Тайлангийн төсөлтэй танилцаад хариугаа 2018 оны 10 сарын 16-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү. ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР, Ч.ЭРДЭНЭБААТАР 1790461	
--	--

Холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан тоот

Тайлбар



Танай 2018 оны 10 дугаар сарын 12-ны 104 тоот албан бичгийн дагуу “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн дүгнэлттэй санал нийлж байна. Цаашид шаардлагатай арга хэмжээг авч, сумдад чиглэл өгч ажиллах болно.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

1. Тайлангийн төсөлд санал ирээгүй тул тайланд өөрчлөлт хийгдээгүй

Тайлангийн баталгаажуулалт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 10 дугаар сарын 22

Дугаар А/27

Чингис хот

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40 дэх заалт, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 2018 оны 04 тоот хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/ -т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

1200146